

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Авто замын сангийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2023/224/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Улаангом хот
2023 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,
Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь
Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn
Аудитын менежер: М.Бат-Амгалан
Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn
Аудитор: С.Батсуурь
Утас: 70453799, Цахим хаяг: Batsuuris@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	11
4.1 Ерөнхий зүйл	12
4.2 Материаллаг байдал	13
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	13
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал 13	
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	13
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	13
4.5.1 Завсрын аудитын талаар	13
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	13
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	14

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
НА	Нийцлийн аудит



УВС АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГА Ч.ЧИМЭД ТАНАА

**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

2023.03.15 № УВА-2023/224/НА-СТА-ТШЗ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасны дагуу Авто замын сангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Авто замын сангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор асуудлыг онцолсон хэсэгт санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн ойлголтыг бүрдүүлэхэд ач холбогдолтой, санхүүгийн тайланд толилуулсан, тодруулсан мэдээлэл байхгүй болно.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

0200200657

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**2.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>0.00</u>	<u>0.00</u>
33	АВЛАГА	<u>0.00</u>	<u>0.00</u>
335	Бусад авлага	<u>0.00</u>	<u>0.00</u>
3351	Байгууллагаас авах авлага	0.00	0.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>0.00</u>	<u>0.00</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>0.00</u>	<u>0.00</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	<u>0.00</u>	<u>0.00</u>
512	Хуримтлагдсан үр дүн	<u>0.00</u>	<u>0.00</u>
51210	Өмнөх үеийн үр дүн	0.00	0.00
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>0.00</u>	<u>0.00</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

№	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	345,000,000.00	400,000,00.00
2	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	345,000,000.00	400,000,00.00
3	Орон нутгийн төсвөөс санхүүжих	345,000,000.00	400,000,00.00
4	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	345,000,000.00	400,000,00.00
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	345,000,000.00	400,000,00.00
6	УРСГАЛ ЗАРДАЛ	345,000,000.00	400,000,00.00
7	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	344,925,152.00	313,244,535.00
8	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	344,925,152.00	313,244,535.00
9	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	344,925,152.00	313,244,535.00
10	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	74,848.00	86,755,465.00
11	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	74,848.00	86,755,465.00
12	Төвлөрүүлэх шүлжүүлэг	74,848.00	86,755,465.00

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

№	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	345,000,000.00	400,580,00.00
2	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		580,000.00
3	Нийтлэг татварын бус орлого		580,000.00
4	Төсөв байгууллагын өөрийн орлого		580,000.00
5	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		580,000.00
6	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	345,000,000.00	400,000,00.00
7	Орон нутгийн төсвөөс санхүүжих	345,000,000.00	400,000,00.00
8	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	345,000,000.00	400,000,00.00
9	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	345,000,000.00	400,580,00.00
10	УРСГАЛ ЗАРДАЛ	345,000,000.00	400,580,00.00
11	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	344,925,152.00	313,244,535.00
12	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	344,925,152.00	313,244,535.00
13	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	344,925,152.00	313,244,535.00
14	Бараа үйлчилгээний бусад зардал		580,000.00
15	Бараа үйлчилгээний бусад зардал		580,000.00
16	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	74,848.00	86,755,465.00
17	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	74,848.00	86,755,465.00
18	Төвлөрүүлэх шилжүүлэг	74,848.00	86,755,465.00
19	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)		
20	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)		

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	0.00	0.00	0.00
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
D01	2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00	0.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	0.00	0.00	0.00
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	ЗГСУМС гүйцэтгэл	Зөрүү
I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	400,000,000.00	313,244,535.00		313,244,535.00
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	400,000,000.00	313,244,535.00		313,244,535.00
Бараа, үйлчилгээний зардал	400,000,000.00	313,244,535.00		313,244,535.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	400,000,000.00	313,244,535.00		313,244,535.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	400,000,000.00	313,244,535.00	313,244,535.00	313,244,535.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	400,000,000.00	313,244,535.00		313,244,535.00
Улсын төсвөөс санхүүжих			313,244,535.00	313,244,535.00
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	400,000,000.00	313,244,535.00		313,244,535.00
Орон нутгийн төсвөөс	400,000,000.00	313,244,535.00		313,244,535.00

2.6 Төсвийн тохируулга

ҮЗҮҮЛЭЛТ	ГҮЙЦЭТГЭЛ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>87,335,465.00</u>
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	580,000.00
Нийтлэг татварын бус орлого	580,000.00
Төсөв байгууллагын өөрийн орлого	580,000.00
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	580,000.00
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	86,755,465.00
Орон нутгийн төсвөөс санхүүжих	86,755,465.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	86,755,465.00
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	86,755,465.00
УРСГАЛ ЗАРДАЛ	86,755,465.00
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	580,000.00
Бараа үйлчилгээний бусад зардал	580,000.00
Бараа үйлчилгээний бусад зардал	580,000.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	86,755,465.00
Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	86,755,465.00
Төвлөрүүлэх шилжүүлэг	86,755,465.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Автозамын сан нь орон нутгийн чанартай авто замын арчлалт, засвар, түүнтэй холбоотой үйл ажиллагааг санхүүжүүлэх зориулалттай сан юм.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Авто замын санд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах, хяналт тавих үйл ажиллагаанд Авто замын тухай, Төсвийн тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж болон энэ журмыг баримтална.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тайлант онд дотоод аудит хийгдээгүй байна. Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Увс аймгийн Авто замын сангийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэль сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн бөгөөд байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Увс аймгийн Авто замын сангийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэлээ.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн аливаа бодлогод өөрчлөлт ороогүй байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 400,000.0 мянган төгрөг, нийт зарлагыг 400,000.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийг 400,000.0 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 400,000.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 400,000.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 313,2 сая төгрөг буюу 78. хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 86,8 сая төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71101/82214	400,000.0	313,244.5	86,755.5	78.3%
	ДҮН	400,000.0	313,244.5	86,755.5	78.3%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Авто замын сангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор С.Батсуурь гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Авто замын сан нь 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 03 дүгээр сарын 03-ны өдрийн 7/367 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 400,000.0 мянган төгрөгийн 1.0 хувь буюу 4,000.0 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 3,200.0 мянган төгрөгөөр тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Авто замын сангийн хувьд хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд биет горим сорилыг хэрэгжүүлсэн.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил гараагүй болно. /АБ-4/

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Увс аймгийн авто замын сангийн хувьд www.shilendans.gov.mn сайтад бие даасан цэсгүй ба шаардлагатай мэдээллээ төсвийн ерөнхийлөн захирагчийн сайтад байршуулдаг байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд зөрчилтэй асуудал байхгүй байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Авто замын сангийн 2022 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар зөрчил илрээгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  /М.БАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР  /М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР  /С.БАТСУУРЬ/

2023 оны 03 дугаар сарын 14-ний өдөр